



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Дархан сумын 8 дугаар цэцэрлэг 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/74/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2025 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр: Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn</p> <p>Аудитор: Э.Эрдэнэбат Утас: 99352099 Цахим хаяг: tsesb.audit@gmail.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
Асуудлыг онцолсон хэсэг	3
Аудитын гол асуудал.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	19
4.1 Ерөнхий зүйл.....	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	20
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
4.5.1 Завсрын аудитын талаар	21
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	21
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	21
5.1 Төлбөрийн акт	18
5.2 Албан шаардлага	22
5.3 Зөвлөмж.....	22
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ХК	Хувьцаат компани
БЕГ	Боловсролын ерөнхий газар
БГ	Боловсролын газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН
8 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Г.ЭНХТУЛГА ТАНАА

2025.02.05 № *97*

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн 8 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна. □

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг □ онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант хугацаанд Боловсрол, шинжлэх ухааны яамны хөрөнгө оруулалтаар 13,408.5 мянган төгрөгийн компьютер, ОНХС-ын хөрөнгө оруулалтаар 8,340.0 мянган төгрөгийн аяга таваг угаагч хүлээн авч, үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж, тайлагнасан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардал 580,533.4 сянган төгрөг болж, өнгөрсөн оны гүйцэтгэлээс 45.7 хувиар өссөн байна.

Бусад асуудал

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Дархан Уул аймгийн Дархан сумын 8 дугаар цэцэрлэгийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 57 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 97 хувиар тайлагнасан байна. Мөн улирал бүр БСУГ-т ажлын тайланг хүргүүлж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР


Ш.МӨНХБАЯР




2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	101,930,956.79	135,743,050.11
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	55,969,720.08	98,906,532.77
312	Банканд байгаа бэлэн мөнгө	55,969,720.08	98,906,532.77
3121	төгрөг		
31211	Төрийн сангийн харилцах		
33	АВЛАГА	-	-
332	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	-
3351	Байгууллагаас авах авлага		
35	БАРАА МАТЕРИАЛ	45,961,236.71	36,836,517.34
351	Түүхий эд материал	857,500.00	857,500.00
3511	Тусгай зориулалттай материал	-	-
3513	Эм боох материал	857,500.00	857,500.00
354	Хангамжийн материал	45,103,736.71	35,979,017.34
35410	Бичиг хэргийн материал	-	28,500.00
35420	Аж ахуйн материал	22,182,045.00	18,491,513.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	-
35440	Түлш, шатах тослох материал	-	-
3545	Барилгын засварын материал		-
3546	Хүнсний материал	7,470,832.59	6,762,303.99
35470	Бусад хангамжийн материал	15,450,859.12	10,696,700.35
36	НӨӨЦ БАРАА		
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,570,281,791.44	1,576,890,006.08
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ		
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,570,281,791.44	1,576,890,006.08
392	Биет хөрөнгө	1,372,405,791.44	1,379,185,256.10
39201	Барилга, байгууламж орон сууц	1,345,636,000.00	1,345,636,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(61,827,930.12)	(73,069,371.96)
39203	Авто тээврийн хэрэгсэл	-	-
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	-
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	40,912,420.00	60,511,320.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(11,287,534.78)	(14,348,614.24)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	62,804,393.00	69,446,493.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(29,599,945.31)	(33,752,197.93)
39214	Бусад үндсэн хөрөнгө	31,542,353.60	31,542,353.60
39215	Хуримтлагдсан элэгдэл	(7,123,467.25)	(8,010,228.67)
39217	Ном	1,349,502.30	1,229,502.30
393	Биет бус хөрөнгө	197,876,000.00	197,704,749.98
39301	Программ хангамж	1,870,000.00	1,870,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(171,250.02)
39303	Бусад биет бус хөрөнгө	196,006,000.00	196,006,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,672,212,748.23	1,712,633,056.19



5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,672,212,748.23	1,712,633,056.19
51	Засгийн газрын хувь оролцоо	1,672,212,748.23	1,712,633,056.19
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	196,006,000.00	196,006,000.00
51101	Өмч: - төрийн	196,006,000.00	196,006,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,467,971,540.33	1,508,391,848.29
51210	Өмнөх үеийн үр дүн	1,467,971,540.33	1,467,971,540.33
51220	Тайлант үеийн үр дүн	-	40,420,307.96
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	8,235,207.90	8,235,207.90
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,672,212,748.23	1,712,633,056.19



2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	674,765,640.00	928,190,280.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	27,192,840.00	23,283,780.00
120	Нийтлэг татварын бус орлого	27,192,840.00	23,283,780.00
12004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	2,198,840.00	1,535,280.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,198,840.00	1,535,280.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	24,994,000.00	21,748,500.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	-	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	647,572,800.00	904,906,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	574,741,300.00	813,469,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	574,741,300.00	813,469,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	2,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		2,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	72,831,500.00	89,437,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /Орон нутгийн төсөвт байгууллага/	72,831,500.00	89,437,300.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	0.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	0.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	637,668,087.95	887,769,972.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	637,668,087.95	887,769,972.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	637,139,099.52	869,732,223.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	398,342,052.70	580,533,404.97
210101	Үндсэн цалин	267,576,239.29	395,253,344.58
210102	Нэмэгдэл	114,889,257.41	167,334,697.39
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00
210104	Урамшуулал	15,876,556.00	17,945,363.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,243,054.70	72,961,826.84
210201	Тэтгэврийн даатгал	34,357,778.10	50,322,243.24
210202	Тэтгэмжийн даатгал	4,040,920.93	5,868,419.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,216,196.75	2,920,860.10
210204	Ажилгүйдлийн даатгал	784,296.26	2,769,963.48
210205	Эрүүл мэндийн даатгал	7,843,862.66	11,080,340.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	69,661,051.57	71,411,931.20
210301	Гэрэл, цахилгаан	10,283,387.21	12,746,618.76
210302	Түлш, халаалт	51,799,440.00	51,799,440.00
210303	Цэвэр, бохир ус	7,578,224.36	6,865,872.44
210304	байрны түрээс	-	-
2104	Хангамж, бараа материалын зардал	1,824,300.00	4,341,800.00
210401	Бичиг хэрэг	1,764,800.00	3,934,800.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.00	0.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	59,500.00	407,000.00
210408	Бараа материал акталсны зардал	0.00	
2105	Нормативт зардал	63,320,860.01	82,036,211.87
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	382,085.00	212,976.50
210502	Хоол хүнс	62,938,775.01	76,566,176.60
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		5,257,058.77
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,805,300.00	14,505,300.00
210601	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	0.00
210604	Урсгал засвар	4,805,300.00	14,505,300.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	0.00
210702	Дотоод албан томилолт	0.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	592,010.00	1,167,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.00	0.00
210805	тээврийн хэрэгслийн оношлогоо	0.00	0.00
210806	мэдээлэл, технологийн үйлчилгээ	592,010.00	1,167,500.00
210807	Газрын төлбөр	0.00	0.00
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	48,350,470.54	42,774,248.36
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,226,590.00	18,780,159.16
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	3,512,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	39,123,880.54	20,481,289.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	528,988.43	18,037,748.80
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	0.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	12,982,400.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		12,982,400.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	528,988.43	5,055,348.80
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	528,988.43	5,055,348.80
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	37,097,552.05	40,420,307.96
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.00	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	0.00	
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	37,097,552.05	40,420,307.96


ХТ05402962870399

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	649,771,640.00	906,441,780.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,198,840.00	1,535,280.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,198,840.00	1,535,280.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	2,198,840.00	1,535,280.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,198,840.00	1,535,280.00
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	647,572,800.00	904,906,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	574,741,300.00	813,469,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	574,740,300.00	813,469,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	2,000,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	-	-
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	2,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хувиарласан хөрөнгө		
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	72,831,500.00	89,437,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	72,831,500.00	89,437,300.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	0.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	0.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	598,496,401.40	855,428,067.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	598,496,401.40	855,428,067.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	597,967,412.97	837,390,318.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	398,342,052.70	580,533,404.97
210101	Үндсэн цалин	267,576,239.29	395,253,344.58
210102	Нэмэгдэл	114,889,257.41	167,334,697.39
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00
210104	Урамшуулал	15,876,556.00	17,945,363.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	-
2102	Ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,243,054.70	72,961,826.84
210201	Тэтгэврийн даатгалын	34,357,778.10	50,322,243.24
210202	Тэтгэмжийн даатгалын	4,040,920.93	5,868,419.44
210203	ҮОМШӨ-ий даатгалын	3,216,196.75	2,920,860.10
210204	Ажилгүйдлийн даатгалын	784,296.26	2,769,963.48
210205	Эрүүл мэндийн даатгалын	7,843,862.66	11,080,340.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	69,661,051.57	71,411,931.20
210301	Гэрэл, цахилгаан	10,283,387.21	12,746,618.76
210302	Түлш, халаалт	51,799,440.00	51,799,440.00


210303	Цэвэр, бохир ус	7,578,224.36	6,865,872.44
210304	байрны түрээс	-	-
2104	Хангамж, бараа материал	-	-
210401	Бичиг хэргийн зардал	-	-
210402	Тээвэр шатахуун	-	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.00	0.00
210404	Ном, хэвлэл	-	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	-
2105	Нормативт зардал	59,039,454.00	75,857,648.00
210502	Хоол хүнс	59,039,454.00	75,857,648.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	-
2106	Эд хогшил урсгал засвар	4,805,300.00	14,505,300.00
210601	Багаж техник хэрэгсэл	-	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	-
210604	Урсгал засвар	4,805,300.00	14,505,300.00
2107	Томилолт, зочны зардал	-	-
210702	Дотоодын томилолт	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж	817,010.00	2,377,300.00
210806	мэдээлэл, технологийн үйлчилгээ	817,010.00	2,377,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,059,490.00	19,742,907.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,720,390.00	12,421,307.50
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	3,339,100.00	7,321,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	528,988.43	18,037,748.80
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	-
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	12,982,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	-	12,982,400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	528,988.43	5,055,348.80
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	528,988.43	5,055,348.80
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
3	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	51,275,238.60	51,013,712.69
4	Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн	-	-
5	Хөрөнгө оруулалтын мөнгөн зардлын дүн	1,000,000.00	8,076,900.00
0	Дотоод эх үүсвэр	1,000,000.00	8,076,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	-
6	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(1,000,000.00)	(8,076,900.00)
8	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	50,275,238.60	42,936,812.69
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	55,969,720.08
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	98,906,532.77



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
S01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	196,006,000.00	8,235,207.90	1,430,873,988.28	-	1,635,115,196.18
S02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
S03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	196,006,000.00	8,235,207.90	1,430,873,988.28	-	1,635,115,196.18
S04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					-
S05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					-
S06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
S07	Тайлант үеийн үр дүн			37,097,552.05		37,097,552.05
S08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	196,006,000.00	8,235,207.90	1,467,971,540.33	-	1,672,212,748.23
D01	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
D02	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	196,006,000.00	8,235,207.90	1,467,971,540.33	-	1,672,212,748.23
D03	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					-
D04	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					-
D05	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
D06	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					-
D07	Тайлант үеийн үр дүн			40,420,307.96		40,420,307.96
D08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	196,006,000.00	8,235,207.90	1,508,391,848.29	-	1,712,633,056.19




2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	982,062,200.00	856,449,618.51	(125,612,581.49)	87.2%
21	Урсгал зардлын дүн	982,062,200.00	848,372,718.51	(133,689,481.49)	86.4%
210	Бараа үйлчилгээний зардал	969,079,800.00	848,372,718.51	(120,707,081.49)	87.5%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	664,428,100.00	580,533,404.97	(83,894,695.03)	87.4%
210101	Үндсэн цалин	473,432,000.00	395,253,344.58	(78,178,655.42)	83.5%
210102	Нэмэгдэл	181,751,500.00	167,334,697.39	(14,416,802.61)	92.1%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	-	-	0.0%
210104	Урамшуулал	9,244,600.00	17,945,363.00	8,700,763.00	194.1%
210105	Гэрээт ажлын хөлс	-	-	-	0.0%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	77,378,600.00	72,961,826.84	(4,416,773.16)	94.3%
210201	Тэтгэврийн даатгал	52,618,900.00	50,322,243.24	(2,296,656.76)	95.6%
210202	Тэтгэмжийн даатгал	6,188,900.00	5,868,419.44	(320,480.56)	94.8%
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,095,100.00	2,920,860.10	(174,239.90)	94.4%
210204	Ажилгүйдлийн даатгал	3,095,100.00	2,769,963.48	(325,136.52)	89.5%
210205	ЭМД-ын хураамж	12,380,600.00	11,080,340.58	(1,300,259.42)	89.5%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	106,618,100.00	71,411,931.20	(35,206,168.80)	67.0%
210301	Гэрэл, цахилгаан	15,575,000.00	12,746,618.76	(2,828,381.24)	81.8%
210302	Түлш, халаалт	67,339,300.00	51,799,440.00	(15,539,860.00)	76.9%
210303	Цэвэр, бохир ус	23,703,800.00	6,865,872.44	(16,837,927.56)	29.0%
2104	Хангамж, бараа материалын зардал	-	-	-	0.0%
2105	Нормативт зардал	81,916,400.00	75,857,648.00	(6,058,752.00)	92.6%
210501	Эм	-	-	-	0.0%
210502	Хоол хүнс	81,916,400.00	75,857,648.00	(6,058,752.00)	92.6%
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	-	-	-	0.0%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,005,300.00	14,505,300.00	10,500,000.00	362.2%
210604	Урсгал засвар	4,005,300.00	14,505,300.00	10,500,000.00	362.2%
2107	Томилолт, зочны зардал	-	-	-	0.0%
210702	Дотоод томилолт	-	-	-	0.0%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	2,377,300.00	2,377,300.00	-	100.0%
210806	мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,377,300.00	2,377,300.00	-	100.0%
210807	Газрын төлбөр	-	-	-	0.0%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,356,000.00	19,742,907.50	(12,613,092.50)	61.0%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,034,400.00	12,421,307.50	(12,613,092.50)	49.6%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,321,600.00	7,321,600.00	-	100.0%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,982,400.00	10,982,400.00	(2,000,000.00)	84.6%
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-	-	0.0%
213101	Засгийн газрын дотоод урсгал шилжүүлэг	-	-	-	0.0%

2132	Бусад урсгал шилжүүлэг	12,982,400.00	10,982,400.00	(2,000,000.00)	84.6%
213204	ажил олгогчоос олгох бусад тэтгэмж урамшуулал			-	0.0%
213208	хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг			-	0.0%
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	12,982,400.00	10,982,400.00	(2,000,000.00)	84.6%
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-	-	0.0%
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг			-	0.0%
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох	-	-	-	0.0%
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг			-	0.0%
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-	-	0.0%
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг			-	0.0%
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	8,076,900.00	8,076,900.00	0.0%
	Дотоод эх үүсвэрээр	-	8,076,900.00	8,076,900.00	0.0%
	Тоног төхөөрөмж		8,076,900.00	8,076,900.00	0.0%
	Бусад хөрөнгө			-	0.0%
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	982,062,200.00	899,386,431.20	(82,675,768.80)	91.6%
120	Нийтлэг бус татварын орлого	1,505,300.00	1,535,280.00	29,980.00	102.0%
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	1,505,300.00	1,535,280.00	29,980.00	102.0%
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	871,438,800.00	813,469,200.00	(57,969,600.00)	93.3%
131001	Төсвөөс санхүүжих	871,438,800.00	813,469,200.00	(57,969,600.00)	93.3%
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого			-	0.0%
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө			-	0.0%
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	109,118,100.00	84,381,951.20	(24,736,148.80)	77.3%
132001	Орон нутгийн төсвөөс	109,118,100.00	84,381,951.20	(24,736,148.80)	77.3%
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	0.00	0.00	0.0%
134002	Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0.00	0.00	-	0.0%
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		55,969,720.08		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		98,906,532.77		
1	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.0%
3	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0%
	АЖИЛЛАГСАДЫН ТОО	27.00	27.00	-	100.0%
	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0%
	Гүйцэтгэх ажилтан	19.00	19.00	-	100.0%
	Үйлчлэх ажилтан	7.00	7.00	-	100.0%



2.6 Аудит хийсэн төсвийн нэмэлт тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	2,000,000.00	2,000,000.00	-	100
21	Урсгал зардлын дүн	2,000,000.00	2,000,000.00	-	100
210	Бараа үйлчилгээний зардал	2,000,000.00	2,000,000.00	-	100
2104	Хангамж, бараа материалын зардал	-	-	-	-
210401	Бичиг хэрэг			-	-
210402	Тээвэр шатахуун			-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	-	-	-	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр			-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	2,000,000.00	-	100
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	2,000,000.00	-	100
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР			-	-
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,000,000.00	2,000,000.00	-	100
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,000,000.00	2,000,000.00	-	100
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,000,000.00	2,000,000.00	-	100



3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Дархан сумын 8 дугаар цэцэрлэг нь “Хүүхэд бүрийн онцлог хэрэгцээнд суурилан эрүүл мэнд, нийгмийн сэтгэл зүй, танин мэдэхүйн хөгжлийг тохирсон арга зүйгээр дэмжлэг үзүүлэн хөгжүүлэх, аюулгүй байдлыг ханган хамгаалах, байгууллагын менежментийг олон талт хамтын ажиллагаагаар хөгжүүлэх” гэсэн эрхэм зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

1. Хүүхдийн ялгаатай байдал, сурах хэв маягийг харгалзан амжилттай суралцах тэгш боломжийг бүрдүүлэх, сургалтын явцад бие даасан, өөртөө итгэлтэй, өөрийгөө илэрхийлэх, ярих, унших талт чадварыг дэмжин, сургалтын үр дүнтэй арга зүй технологийг бүтээлчээр хэрэглэж гадна дотор орчинд хүүхэд хөгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, сургалтын чанарыг дээшлүүлэх,
2. Багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээнд суурилан судалгаа дүгнэлттэй ажиллах, мэргэжлийн хөгжлийн бүлгийн хамтын ажиллагааны үр дүнг сайжруулж, үзүүлэх ажил, нээлттэй үйл ажиллагаагаар сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, багш ажилтны мэргэжлийн онол арга зүйн мэдлэг чадамжийг сайжруулах сургалт арга хэмжээг зохион байгуулах,
3. Хүүхэд хамгааллын ажлыг хэрэгжүүлэх, багшийн ёс зүй, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг дагаж, мөрдөх,
4. Хоол үйлдвэрлэлийн чанарыг сайжруулах, шим тэжээллэг, цагаан идээ, жимс, ногоон ургамлын хэрэглээг нэмэгдүүлэх, зохистой дадал хэвшилд сургах, хоол бэлтгэх, хадгалах, боловсруулах орчин нөхцөлийг сайжруулах,
5. Эцэг эх, гэр бүл, олон нийттэй хамтран ажиллаж, эцэг эх хүүхдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл мэндийн чиглэлийн ажил зохион байгуулах,
6. Багш ажилтны эрүүл мэндийн багцын үзлэг шинжилгээг бүрэн хамруулж, ажлын байран дээр уламжлалт анагаахын тусламж үйлчилгээг хүргэх, дархлаа дэмжих ажлын байрны дасгал хөдөлгөөнийг хэвшүүлэх, гар бөмбөгийн секцэд бүрэн хамруулах,
7. Байгууллагын гадна болон дотоод орчинд хөрөнгө оруулалт татан төвлөрүүлж хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлэх гэж тодорхойлсон байна.

Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Хүүхдийн эрхийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Сангийн сайдын “Аргачлал, зардлын норматив батлах тухай” 2022 оны А/23,27 дугаар тушаал зэргийг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 53 дугаар тогтоол “Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр, журам батлах тухай”,
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 25 дугаар тогтоол “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх”,
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 84 дүгээр тогтоол “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай”,

- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 82 тоот тогтоол “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох”,
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 104 тоот тогтоол “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн багш ажилтанд мөнгөн тэтгэмж олгох”,
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 237 тоот тогтоол “Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай”,
- Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын хамтарсан 2024 оны А/85, А/34 дүгээр тушаал “Орон тооны хязгаарын жишиг норматив батлах тухай”,
- Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын хамтарсан 2024 оны 115 тоот дугаар тушаал “Цэцэрлэг, ЕБС-ийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх дүгнэх”

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан Уул аймгийн Дархан сумын 8 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг газрын даргын 2021 оны А/02 дугаар тушаалаар баталж, мөн оны 01 дүгээр сараас мөрдөж эхэлсэн бөгөөд өөрчлөлт ороогүй, нягтлан бодох бүртгэлийн стандарт, санхүүгийн программтай нийцсэн байна. Сангийн сайдын 2025 оны А/3 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх НББ-ийн журам”-ыг үндэслэн 2025 оноос Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулж мөрдөж ажиллана.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан Уул аймгийн Дархан сумын 8 дугаар цэцэрлэг нь 2024 оны санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйл, УСНББОУС -ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 45,475.7 мянган төгрөгөөр буюу 2.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	55,969.7	98,906.5	42,936.8
Авлага	-	-	-
Бараа материал	45,961.2	36,836.5	(9,124.7)
Үндсэн хөрөнгө	1,570,281.8	1,576,890.0	6,608.2
Нийт хөрөнгө	1,672,212.7	1,712,633.1	40,420.3
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,672,212.7	1,712,633.1	40,420.3
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,672,212.7	1,712,633.1	40,420.3

Тайлант онц эцэст төвлөрсөн мөнгөнөөс 42,936.8 мянган төгрөг үлдэж, төрийн сангийн харилцах дансанд үлдэгдэл 98,906.5 мянган төгрөг байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 36,836.5 мянган төгрөг болж 9,124.7 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 104,482.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, тус цэцэрлэгийн эрхлэгчийн 2024 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн А/45 тушаалаар 5,664.1 мянган төгрөгийн аж ахуй болон хангамжийн материал акталсан, үйл ажиллагаанд 107,943.4 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулсан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,576,890.0 мянган төгрөг болж 6,608.2 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 8,076.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 7 ширхэг 13,408.5 мянган төгрөгийн компьютер, ОНХС-ын хөрөнгө оруулалтаар 1 ширхэг 8,340.0 мянган төгрөгийн аяга таваг угаагч буюу нийт 21,748.5 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус үнэ төлбөргүйгээр хүлээн авч, Дархан-Уул аймгийн Засаг даргын 2024 оны 01-А/313 тоот захирамжаар 3,704.4 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, тайлант онд 20,481.3 мянган төгрөгийн элэгдэл байгуулж, акталсан 968.5 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэл хасагдсан зэргээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,712,633.1 мянган төгрөг болж 40,420.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагч 2024 оны төсвийн төсөлд нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,172,918.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 109,118.1 мянган төгрөгөөр, өөрийн орлогыг 1,505.3 мянган төгрөгөөр нийт зарлагыг 1,283,542.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

2024 оны батлагдсан төсвийг улсын төсвөөс 811,456.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 92,623.4 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 1,505.3 мянган төгрөг, өмнөх оны үлдэгдэл 55,969.7 мянган төгрөг нийт 961,555.2 мянган төгрөгийн эх үүсвэрийг баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхдээ 871,438.8 мянган төгрөгийг улсын төсвөөр, 109,118.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөр, 1,505.3 мянган төгрөгийг өөрийн орлогоор бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 813,469.2 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос 765,447.0 мянган төгрөг зарцуулж, орон нутгийн төсвөөс 89,437.3 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос 84,382.0 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдсэн 5,055.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна. Мөн өөрийн орлогын 1,535.3 мянган төгрөгийг 100% зарцуулсан.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 856,449.6 мянган төгрөг буюу 87.2 хувьтай байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд 125,612.6 мянган төгрөгийн зардлыг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71801-Сургуулийн өмнөх боловсрол				
1.1	81807- Цэцэрлэгийн хүүхдийн хоол	81,916.4	75,857.6	(6,058.8)	92.6%
1.2	81605-Эрүүл мэндийг дэмжих	2,931.1	1,352.0	(1,579.1)	46.1%
1.3	81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	2,792.4	2,792.4	-	100.0%
1.4	81823-Багш, ажилчдын мэргэжил дээшлүүлэх	1,689.6	1,689.6	-	100.0%
1.5	81834-Боловсролын стандарт, сургалтын хөтөлбөр	759,573.0	660,793.9	(98,779.1)	87.0%
1.6	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагаа	25,418.8	25,418.8	-	100.0%
1.7	80111-Тогтмол зардал	106,618.1	87,422.5	(19,195.6)	82.0%
1.8	80233-Хүүхэд хамгаалал	1,122.8	1,122.8	-	100.0%
Нийт дүн		982,062.2	856,449.6	(125,612.6)	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Ахмад настны тухай хуулийн 14.7-д “Аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална” гэж заасан заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Тайлант онд тус цэцэрлэг нь удирдах 1 ажилтан, гүйцэтгэх 176 ажилтан, үйлчлэх 39 ажилтан буюу нийт 216 ажилтантайгаар ажиллаж, 210801- Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжын зардалд 95,880.7 мянган төгрөг, 210901- Бараа үйлчилгээний бусад зардалд 444,948.4 мянган төгрөгийг зарцуулж, худалдан авах ажиллагаатай холбоотой 933,058.4 мянган төгрөгийн ажил, үйлчилгээ төлөвлөж ажилласан байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан

гаргах үүрэгтэй. Тайлант онд Аймгийн Засаг даргаас нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардалд хуваарилсан 2,000.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт Авч зориулалтын дагуу зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагааг сар тутам зохион байгуулсан ч нэг оролцогч оролцоогүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 8 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын бараа ажил, үйлчилгээний төлбөр тооцоо, зардлын данс болон Шилэн дансны тухай хууль, Ахмад настны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “ЦЭСБ-Аудит” ХХК-ийн аудитор Э.Эрдэнэбат гүйцэтгэж, анхан шатны хяналтыг аудитын менежер Т.Эрдэнэтуяа, захирал Ч.Цэрэннадмид, чанарын хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Дархан сумын 8 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 8 тоот албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны санхүүгийн тайланг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны хагас жилийн орлого үр дүнгийн тайлангийн нийт зардал 637,668.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 6,376.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Дархан Уул аймгийн Дархан сумын 8 дугаар цэцэрлэгийн 2024 оны төсвийг батлахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд цалингийн зардлыг 83,894.7 мянга, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг 4,416.8 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 35,206.2 мянган төгрөг, хоол хүнсний зардал 6,058.8 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 4,436.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэн гүйцэтгэлээр 118,557.2 мянган төгрөгийг хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 5 шалгуур үзүүлэлтээр шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээнээс 1 мэдээг хугацаа хоцроож байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8 дахь заалтуудтай нийцэхгүй байна.

Тус цэцэрлэг нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6.1.1-т “тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор”, 6.1.3-т “дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны системд мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах зөвлөмж хүргүүлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д " Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу “Ахмадын сан” байгуулж, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан “Ахмадын сан байгуулан ажиллах журам”-ын дагуу сангийн хөрөнгийг бүрдүүлж зарцуулан, гүйцэтгэлийг тайлагнаж, хяналт тавьж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус цэцэрлэгийн 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийхэд илрүүлсэн алдаа, зөрчил гараагүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 3,506.7 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн биелэлт 100 хувийн хэрэгжилттэй байна.

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	тоо	дүн	тоо	дүн	хувь
Зөвлөмж	2	3,506.70	2	3,506.70	100%
Нийт дүн	2	3,506.70		3,506.70	

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Боловсролын ерөнхий газрын 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр баталсан 623,448.7 мянган төгрөгийн төсвийн хуваарийг 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр 190,020.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 2024 оны 12 дугаар сарын 28-ны өдөр 91,067.1 мянган төгрөг төвлөрсөн тул харилцах дансны үлдэгдэл өсөж төсвийн гүйцэтгэл 87.2% хувьтай гарсан байна. Иймд төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудлыг дараагийн шатны аудитаар шалгаж, шийдэл гаргах нь зүйтэй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 13,408.5 мянган төгрөгийн алдаа¹ илрүүлж, аудитын явцад залруулав. Үүнд:

- Тайланд онд Боловсрол, шинжлэх ухааны яамны хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүй хүлээн авсан 13,408.5 мянган төгрөгийн 7 ширхэг зөөврийн компьютерийг орлогод авахдаа үндсэн хөрөнгийн тайланд бусад хэсгээр бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл “Нягтлан бодох бүртгэлийн зарчим” 5.1.4. “үнэн зөв байх” заалт, _УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, санхүүгийн тайлангийн аудитын “Ангилал”, Оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул үндсэн хөрөнгийн тайланд хандиваар бүртгэж залруулав.

Мөн аудитаар нийт 4,039.5 мянган төгрөгийн зөрчил² илэрсэн тул зөрчлийг таслан зогсоох 3,088.0 мянган төгрөгийн албан шаардлага, цаашид үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах 951.5 мянган төгрөгийн зөвлөмж хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

Аудитын явцад төлбөрийн акт тогтоогоогүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

5.2 Албан шаардлага

5.2.1. Илрүүлэлт:

Тайлант онд байгууллагын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар “өөрчлөлтгүй” дүгнэлт авсан шалтгаанаар Дархан-Уул аймгийн Боловсролын газрын даргын А/141 дүгээр тушаалыг баримтлан цэцэрлэгийн эрхлэгч үндсэн цалинг 2 дахин нэмэгдүүлж, 3,088.0 мянган төгрөгийн урамшуулал авсан нь Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2 дахь хэсэгт заасантай нийцээгүй тул албан шаардлага хүргүүлэв.

5.2.2. Илрүүлэлт:

Тайлант онд тус цэцэрлэг нь хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээг баримтлаагүйгээс хоолны махны нормативт хэмжээг 951.5 мянган төгрөгөөр хэтрүүлсэн нь Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2020 оны А/166, А/559, 222 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Цэцэрлэгийн насны хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ”-тэй нийцээгүй тул албан шаардлага хүргүүлэв

5.3 Зөвлөмж

Санхүүгийн тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмж байхгүй.

Тайлангийн 4.4.1-т дурдсан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил, мөн 4.4.2-т Ахмад настны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчилд өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5³-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

³ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Зааруулсан		Зааруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Үндсэн хөрөнгийг орлогоор бүртгэхдээ ангиллыг буруу бүртгэж авсан байна.	1	13,408.5	-	-	1	13,408.5	1	13,408.5	-	-	-	-
Дүн	1	13,408.5	-	-	1	13,408.5	1	13,408.5	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дархан-Уул аймгийн Боловсролын газрын даргын А/141 дүгээр тушаалыг баримтлан цэцэрлэгийн эрхлэгч үндсэн цалинг 2 дахин нэмэгдүүлж, 3,088.0 мянган төгрөгийн урамшуулал авсан	1	3,088.0	-	-	1	3,088.0	-	-	-	-	-	-
Тус цэцэрлэгийн хүүхдийн хоолны махны норматив хэмжээг хэтрүүлэн тооцож олгосон байна.	1	951.5	-	-	1	951.5	-	-	-	-	-	-
Дүн	2	4,039.5	-	-	2	4,039.5	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал /мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж	
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны цахим системд, байгууллагын батлагдсан төсөв мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	1	-					1	-
Тус цэцэрлэг нь Ахмад настны тухай хуулийн 14.7 заасан "Төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах" заалтыг зөрчиж ахмадын сан байгуулаагүй байна.	1						1	
Дүн	2	-					2	-